

Герман төмсний салат

Орц

- 0,5 кг төмс
- 4 зүсэм гахайн утсан мах
- ½ сонгино
- 1 цайны халбага нунтагласан сармис
- 2 халбага гич
- 2 халбага алимны цуу
- ¼ аяга яншуй
- Давс, перц

Заавар

1. Төмсөө 8-10 минут буцалгасны дараа хүйтэн усанд хийнэ. 1 см орчим дөрвөлжилж хэрчинэ.
2. Гахайн утсан махыг 4 минут орчим шаржигнуур болтол шарж дараа нь жижиглэн 1 см орчим болгон хэрчинэ.
3. Тухайн гахайн махыг шарсан хайруулын тавганд хэрчсэн сонгиноо 2 минут орчим болгосны дараа сармисаа нэмж ахин 1 минут шарна. Гич, цууг нэмж бага зэрэг бор өнгөтэй болсны дараа төмс, гахайн утсан махан дээр нэмнэ. Яншуй, давс, перцээр амталснаар бэлэн болно.

